



**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2025 оны 12 сарын 26 өдөр

Дугаар A/90

Улаанбаатар хот

**Байгууллагын тусламж, үйлчилгээний шуурхай
бэлэн байдлыг хангах тухай**

Монгол Улсын Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/36 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 1/6227 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүх нийтээр тэмдэглэх Шинэ жилийн баяр, амралтын өдрүүдэд зоонозын халдварт өвчин, дэгдэлт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын хариу арга хэмжээ авах, байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах дуудлагад үйлчлэх баг, хариуцлагатай жижүүрийн нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Бүх нийтийн амралтын өдрүүдэд халдварт өвчний дуудлагын багийн бэлэн байдал, хариу арга хэмжээг тухай бүр зохион байгуулан, байгууллагын цахилгаан, дулаан, гадна орчны аюулгүй байдалд хяналт тавьж, мэдээ мэдээллийг төвийн удирдлагад өглөө бүрийн 09:00 цагт өгч ажиллахыг хариуцлагатай жижүүрийн багт үүрэг болгосугай.

3. Төвийн тусламж үйлчилгээний мэдээллийг Эрүүл мэндийн бүртгэлийн АМЗ6 маягтын дагуу гаргаж, хугацаанд нь Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлэхийг Биостатистикч Х.Бурмаад хариуцуулсугай.

4. Цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой, яаралтай шийдвэрлүүлэх асуудал, зоонозын халдварт өвчин, дэгдэлт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед төвийн захирал болон холбогдох албаны дарга нарт шуурхай мэдээллэж, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг сарын дуудлагын баг, бага эмч нар, Зоонозын өвчин судлалын төвүүдийн дарга нарт тус тус даалгасугай.

5. Яаралтай дуудлагын үед шаардагдах багаж, тоног төхөөрөмж, оношлуур урвалж, халдвар хамгааллын хувцас хэрэгсэл, шатахуун, тослох материал, цахилгааны нэмэлт эх үүсвэрээр хангах, гал түймэр аваар ослоос урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, яаралтай үед объектоос гаргах бараа материал, эд зүйлсийн зөвшөөрөл олгох, дуудлагад үйлчлэх автомашинуудын бэлэн байдлыг хангаж, ажиллахыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Болормаа)-д т зөвшөөрсугүй.

6. Эрүүл мэндийн яамнаас гаргасан холбогдох тушаал, шийдвэр болон энэхүү тушаалын хэрэгжилтийг хангуулах, нийт ажилтан албан хаагчдад танилцуулах, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны албаны дарга (У.Нямжаргал)-д даалгасугай.

**ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ**



Б.АМГАЛАНБАЯР

5.	Аж ахуйн менежер О.Сансар-89104700	Байгууллагын аюулгүй байдлыг хангах, гэнэтийн гамшиг, осол, тог цахилгаан, ус дулааны эрсдэл үүссэн тохиолдолд үйл ажиллагааг хэвийн явуулах ажлыг яаралтай зохион байгуулах. Гар утсыг байнга нээлттэй байлгаж, дуудлага авах бэлэн байдлыг хангах, шаардлагатай тохиолдолд хэрэглэх багаж хэрэгслийн нөөцийг бэлтгэх.
70282853 дугаартай утсаар 24 цагийн турш иргэдэд мэдээлэл зөвлөгөө өгнө.		